

ХҮНИЙ ОРШИХУЙН ФЕНОМЕНЫ ТУХАЙ АСУУДАЛД

Б. Дагзмаа (Доктор Ph.D)

О. Болор-Эрдэнэ (Философийн ухааны магистр)
МУИС, ШУС, Философи, шашин судлалын тэнхим

Түлхүүр үгс: Ахуй ба ухамсар, феномен, Би-гийн ахуй, бодгаль туршлага, экзистенциал, цэвэр субъектив төлөв

Товч утга: Экзистенциализм бол хүний оршихуйн тухай асуудлыг онцлон авч үздэг XX зууны философийн сургаал юм. Уг философийн сургаал хүний тухай уламжлалт хэвшмэл ойлголтуудыг шүүмжлэх замаар экзистенциал онтологийг бүтээсэн байдаг. Ийм онтологи сургаал боловсруулахад арга зүйн хувьд нөлөөлсөн баримтлал бол феноменологи юм. Трансцендентал субъектийн онтологи статусыг феноменологи үндэслэсэн явдал нь экзистенциализмд онолын хувьд чухал нөлөө үзүүлжээ.

* * * * *

Экзистенциализм өмнөх үеийн философийн уламжлалыг шинээр ухамсарлан боловсруулж XX зууны философи сэтгэлгээнд, түүгээр барахгүй оюуны соёлын бусад төрөлд гүнзгий нөлөө үзүүлсэн байдаг. Уг үзэл санаа урлаг, уран зохиол, яруу найрагт хүртэл тусгалаа олсон. Экзистенциализмын ийм өргөн далайцтай нөлөөг дараах байдлаар тайлбарладаг. Үүнд: “капитализмын хямрал”, даян дэлхийг хамарсан их дайнд хүргэсэн нийгэм улс төрийн үймээн, түүнтэй хамт хүн төрөлхтний “мөнхийн үнэлэмжүүд”-ийн тухай дахин эргэцүүлэн үзэх шаардлага ... зэрэг шалтгааныг судлаачид онцолдог. Эдгээр түүхэн үйл явдал экзистенциализм үүсэж, оршин тогтнох нийгэм соёлын чухал нөхцөл болж өгсөн нь тодорхой юм. Мөн нөгөөтэйгүүр оршихуйн философи бий болсон дотоод шалтгаан, утга холбогдлыг тодорхойлохын тулд тус философийн хүрээнд ахуй, оршихуйн тухай асуудлыг хэрхэн шийдсэнийг судлан үзэх шаардлагатайг энд өмнөтгөл болгон дурдах хэрэгтэй билээ.

Ахуйн тухай асуудалд сонгодог философи янз бүрийн байр сууринаас (материалист, идеалист, шашны трансценденталист) хандаж ирсэн. Харин онтологийн уламжлалт үзэл санааг экзистенциалист философчид шүүмжлэх замаар өөрсдийн сургаалаа боловсруулжээ. Ахуйг “эртний Грекийн философи космосын дэг журамд, дундад зууны философи Бурхан тэнгэрт, шинэ үеийн философи оюун санаанд”¹ үндэслэн үзэж байсан бол, экзистенциализм ахуйн тухай асуудалд хүний оршихуйн үүднээс ханддаг гэж тэд тодорхойлжээ. Экзистенциалист философичидийн анхаарлын төвд Би-гийн ахуй ба түүний экзистенциалуудын тухай асуудал оршиж байдаг бөгөөд хүний “туулан мэдэрсэн” аймшиг, зовиол, ганцаардал гэх мэт сэтгэлийн зовиурт элементүүд ахуйг тодорхойлдог онтологи категорийн үүрэг гүйцэтгэх болсон байна.

Хэдий экзистенциалист философичдийн сургаал ялгаатай байдаг ч тэдгээрт нийтлэг үзэл санаа байгааг бид дараах байдлаар тодорхойлох боломжтой юм. Иймд тэд:

Би-гийн ахуйн тухай асуудлыг философидолтынхоо гол сэдэв болгодог;

¹ Современный экзистенциализм. Критические очерки. – М., 1966. – С. 32.

Субъектив онтологийн үүднээс уламжлалт метафизикийг шүүмжилдэг;

Судлагааны суурь арга зүйгээ феноменологи философитой нягт холбодог;

Хүний оршихуйн феноменуудыг философийн бие даасан категори болгон хэрэглэдэг юм.

Сонгодог үеийн философид ахуй болон оршихуйн тухай асуудлыг мөн чанартай холбон үзэж, *ахуйг олох түлхүүр бол мөн чанар* мөн гэсэн үзлийг баримталдаг байв. Тухайлбал, Платоны хувьд мөн чанар бол санаа мөн. Түүний энэ үзлээр хүний сүнс өөрийн жинхэнэ ахуйгаасаа салж хүнийссэн байдаг тул түр зуурын ертөнц дэх түүний оршихуй нь мөнхийн санааны ертөнц дэх мөн чанартай нь зөрчилдөж, чухамдаа энэ нь хүний эмгэнэлт дүр зургийг (existential)* бий болгож байдаг.

Харин экзистенциализм ахуйн тухай асуудлыг хүнээс тусдаа шийдвэрлэдэг ийм үзэл санааг эс хүлээн зөвшөөрч, ерөөс ахуй Би-гийн ахуйгаар дамжин нээгддэг гэсэн үзлийг баримталсан. Ингэхдээ экзистенциализмд Би-гийн ахуй төдийгүй ерөөс ахуйн субстанци² бол “оршихуй” гэдэг категори байдаг. Өөрөөр хэлбэл, тэд “Би-гийн ахуй оршихуйд оршдог” хэмээн үзэж, ахуйг хүний оршихуйтай холбон үзэж субъектив онтологийн нэг хувилбарыг боловсруулсан юм.

Хүн хэмээх бодгалийн хувьд объектив зүйлээс (эссенцээс) субъектив ахуй нь (экзистенци) илүү чухал гэж философийн экзистенциализм үздэг. Энэ нь Р.Декартаас Г.Гегель хүртлэх шинэ үеийн философид давамгайлж байсан хүний тухай рациональ тайлбарын шүүмжлэлийн үр дүн байлаа. Тухайлбал, Г.Гегелийн хувьд: “Би” бол ухамсрын эцсийн, эгэл мөн чанар мөн. “Би”, сэтгэхүй хоёр нэг л зүйл юм гэж бид үзэж болно; эсвэл илүү тодорхой хэлбэл: “Би” бол сэтгэж байгаа сэтгэхүй мөн ... Бидний өмнө байгаа “Би” бол цэвэр бодол мөн. Адгуус “Би” гэж хэлэх чадваргүй, үүнийг гагцхүү хүн л чадна, учир нь хүн бол сэтгэхүй мөн”³. Тэгвэл хүний оршихуйг сэтгэхүйгээр нь төлөөлүүлж үздэг ийм рациональ үзэлд XIX зуунд Данийн теологич, уран зохиолч С.Киркегаард шүүмжлэлтэй хандаж үзэл санаагаа боловсруулснаар экзистенциалист философийн үндэс тавигдсан билээ. Түүний үзлээр Г.Гегель төдийгүй ер нь Германы сонгодог философид хүний хувьд хамгийн чухал зүйл болох “оршихуй” тусгалаа олоонгүй. С.Киркегаардийн үзлээр “адгуус амьтаны ертөнц нь төрөлд нэгж захирагдах ёстой гэсэн зарчимтай. Харин хүн төрөлхтөний хувьд гэвэл индивид Бурхан тэнгэрийн төсөө ба дүрээр бүтээгдсэн тул тэрээр төрөлд захирагдах учиргүй”⁴ билээ. Хүний оршихуй дахин давтагдашгүй, төгсөглөг шинжтэй учир түүнийг рациональ нотолгоонд тулгуурлан (оюун ухааны категориор) тайлбарлах боломжгүй, мөн хүний амьдралын хувь тавиланг тааж мэдэхийн аргагүй, тэр нь дур зорогын шинжтэй. Иймд С.Киркегаардийн философийн үндсэн зарчмыг “амьдрал бол логик биш, тиймээс хүний оршихуй зөрчилтэй-ээдрээтэй-эмгэнэлтэй” гэж томъёолж болох юм⁵.

Үүнээс үзвэл:

- оршихуйн тухай асуудлыг мөн чанарыг тодорхойлдог оюун ухааны категорид захируулан шийдвэрлэх боломжгүй;
- оршихуйг бусад юмсын нэгэн адил объект болгон судлах боломжгүй;
- оршихуй бол Би-гийн ахуйн нууц үндэс мөн;
- тийм болохоор философийн экзистенциализм нь бусад философи сургаалаас эрс ялгаатай үзэл санааны өөр удирдамжийг шаарддаг.

Сонгодог философи ахуйг метафизикийн ерөнхий категориудаар дамжуулан

* Платоны философид ертөнцийн оршихуй тогтворгүй, түр зуурын шинжтэй байдаг тул сөрөг утга илэрхийлдэг.

³ Гегель Г. В. Ф. Энциклопедия философских наук. – М., 1974. Т. 1. – С. 123.

⁴ Субстанци (sub-доор нь, stare -байх) - юмсын гадаад шинж чанар өөрчлөгдсөн ч үүнд үл өртөн тогтмол үлддэг ямар нэгэн зүйл, суурь үндэс, язгуур чанар

⁵ Тэрээр ийм үзэл санаагаа «эсвэл-эсвэл» гэсэн экзистенциал диалектикийн аргаар илэрхийлжээ (См.: Антология мировой философии. – М., 1971. Т. 3. // Кьеркегор С. Или-или. – С. 710-724)

тодорхойлдог. Үүнд, Аристотелийн категорийн хэллэгүүд, Г.Гегелийн диалектик категориудыг дурдаж болох юм. Мөн И.Кантын априори категориуд бодомжийн логик функцийг илэрхийлддэг бөгөөд тэдгээр нь оюун бодлын ерөнхий хэлбэр юм. Өөрөөр хэлбэл уг ерөнхий категориуд нь экзистенциалист философичдын үзлээр хэлзүйн үүднээс “юу” гэж асууж болох “бэлэн ахуйг”⁶ илэрхийлдэг. Гэтэл “Би-гийн ахуй” “дахин давтагдашгүй, төгсөглөг шинжтэй”, “объект болдоггүй” тул “бэлэн ахуйг” тодорхойлдог категориудаар дамжин илэрхийлэгдэхгүй. Зарим оршихуйн философчид, ялангуяа Хайдеггер энэ байдлыг тооцон үзээд “Би-гийн ахуйн” экзистенциал онтологийн категориудыг буюу экзистенциалуудыг бий болгосон (“ертөнц-дэх-ахуй”, “бусад-тай-ахуй”, “үхэл-руу-ахуй”, “аймшиг”, “тууштай байдал” гэх мэт) юм. “... Дазайны ахуйг экзистенциалууд тодорхойлдог. Категориуд хэмээн нэрлэдэг бэлэн ахуйн тодорхойлолтоос тэдгээр нь ялгаатай”⁷ гэж М.Хайдеггер бичжээ.

Нэгэнт “оршихуйг” “юу-ахуй” тодорхойлох боломжгүй тул, хэл зүйн үүднээс “оршихуй гэж юу вэ?” гэж бид асуух ёсгүй. Харин “Би-гийн ахуй” “хэрхэн” оршдог вэ? гэж асуух ёстой ажээ⁸. Учир нь “бэлэн ахуйг”-аас ялгаатай нь хүн өөрийн ахуйгаа бүтээх чадалтай оршино. Үүнийг Ж.П.Сартр “оршихуй мөн чанараас түрүүлдэг” хэмээх зарчмаар илэрхийлжээ. Тиймээс Би-гийн ахуй бол өөртөйгөө адил байгаад зогсохгүй, өөрийн хязгаараа ямагт даван туулж байдаг өөрөөр хэлбэл өөртөө түгжигдмэл буюу субстанционал мөн чанар бүхий зүйл биш юм. Мөн экзистенциалист философийн өөр нэгэн төлөөлөгч К.Ясперсийн хэлдгээр “хүн бол бэлэн ахуй дахь бололцоотой оршихуй мөн”⁹. Өөрөөр хэлбэл, хүний оршихуй нь түүний эмпирик илэрлүүдээс ямагт түрүүлдэг, түүний нөхцөл болж байдаг. Энэ нь “юу” гэдэг тодорхойлолтоос өмнө хүн “оршдог” гэсэн үг юм. Оршихуй бол Ясперсийнхаар Би-гийн ахуйн үндэс.

Дээрхи санааг цааш нь үргэлжлүүлвэл Би-гийн ахуйн үзэгдлүүдийг “объект-субъект” хэлбэрээр танин мэдэх боломжгүй бөгөөд хүн “объект” болж хувардаггүй тэр л нөхцөлд бодгаль туршлага бий болдог аж. Би-гийн ахуй үл объективчилогдоно. Хүний оршихуйн феномен руу нэвтрэхийн тулд “объект-субъект” гэх танин мэдэхүйн загвараас хөндий байж, түүнийг гаднаас нь нөхцөлдүүлдэг мөн чанарын тухай ярихаас эрс татгалзах ёстой. Хэт рациональ сэтгэлгээ бол объект-субъектын эсрэгцэлд үндэстэй бөгөөд ертөнцийг объектив ба субъектив хэсэг болгон албадан хуваадаг хэмээн экзистенциалистууд шүүмжлэдэг юм. Тэдний үзлээр жинхэнэ философи нь объект, субъект хоёрын нэгдлээс эхлэх ёстой. Энэ нэгдэл Би-гийн ахуйд хэрэгждэг.

Хүний оршихуйн тухай асуудал бол философийн экзистенциализмын үндсэн сэдэв мөн. Гэтэл энэ нь зөвхөн экзистенциализм төдийгүй мөн персонализм, амьдралын философи гэх зэрэг хүний тухай философи баримтлалуудын асуудал байдаг бөгөөд тэдгээр нь үзэл санааны хувьд оршихуйн философитой төсөөтэй “амьдрал”, “бие хүн”... гэх мэт ойлголтыг бас цөөнгүй хэрэглэдэг. Тухайлбал, А.Шопенгауэр “бидний амьдарч байгаа орчлон тэр чигээрээ хүсэл эрмэлзлэлээр тодорхойлогддог”¹⁰ гэж үздэг. Энд дурдагдаж буй “амьдрал-хүсэл эрмэлзлэл” зэрэг ойлголт сонгодог философийн дээд эрхэмлэл-юмсын учир шалтгааныг илрүүлж чаддаг оюун ухааны эсрэг байдгаараа экзистенциализмтай төсөөтэй юм. Гэхдээ А.Шопенгауэр, Ф.Ницше нар “хүсэл эрмэлзлэл”-ийг хүн төдийгүй ургамал, амьтан зэрэгт хамааруулан метафизик ерөнхий категори болгон ашигладаг нь экзистенциалист философиос ялгаатай билээ. Харин персонализмд “бие хүн” (персон) хэмээх категори байдаг бөгөөд уг үзлийн томоохон төлөөлөгч Н.О.Лосскийн үзлээр ертөнц “субстанциал үйлдэгч”¹¹-үүдийн

⁶ Реале Д. Антисери Д. Западная философия от истоков до наших дней. Том 4. - СПб., 1997. - С.155.

⁷ Хайдеггер. М. Бытие и время. - М., 1997. - С. 44.

⁸ См.: Больнов О. В. Философия экзистенциализма. - СПб., 1999.

⁹ Ясперс К. Философия. Книга вторая. Просветление экзистенции. - М., 2012. - С. 7.

¹⁰ Шопенгауэр А. Мир как воля и представление. // Хрестоматия по истории философии. В 3 ч: Ч. 2. - М., 1997. - С. 52.

¹¹ Субстанциальный деятель гэдгийг ийнхүү орчуулав.

шатлалаас тогтодог. Ийм тогтолцоонд субстанциал үйлдэгч бүр үл давтагддаг, онцгой элемент бөгөөд өөрийн гэсэн үүрэг зориулалттай. Тэдгээрийн уг чанар орон зай, цаг хугацаанаас ангид орших бөгөөд зөвхөн илрэл нь физик болон психик хэлбэрийг олж авдаг. Тэдгээр нь бие биеэ болон Бурхан тэнгэрийг хайрлаж, ахуйн бүрэн бүтэн байдлыг бий болгодог. Энэ шатлалын оргилд Бурхан тэнгэрлэг Бие хүн-Персон оршдог ажээ. Гагцхүү нүгэлд автсан энэ ертөнцийн хүн л (тухайлбал, хувийн өмчид хэт шунасан хүн) цаг хугацаанд захирагдаж, психофизик орон зайгаар хязгаарлагддаг (учир нь өмч бол психофизик орон зай юм) учиртай. Тийнхүү потенциал ба актуал бие хүнээс ертөнц тогтодог гэж персонализм үзэж байгаа билээ¹². Ийнхүү персонализмд бие хүнийг универсалжуулж космологийн утгатай категори болгон хувиргажээ. Харин экзистенциализмын үүднээс бол хүн ертөнцийн нэг хэсэг биш, ертөнц хүний оршихуйн хэсэг мөн гэдгийг онцлох хэрэгтэй юм. Тухайлбал, Ж.П. Сартрын тодорхойлсноор “хүнийг объект болгодоггүй цорын ганц онол”¹³ бол экзистенциализм ажээ. Иймд хүн бол эрх чөлөөтэй, өөрийгөө тодорхойлдог оршихуй буюу цэвэр “субъектив төлөв”. Уг субъектив төлөв бол: 1-рт, гадаад хүчин зүйлсээс шалтгаалдаггүй. Тухайлбал, нийгэм, үндэстэн, хүйс болон бусад эмпирик нөхцлөөс үл хамаардаг¹⁴. 2-рт, энэ нь ухамсрын психофизик үйл явцтай огт холбоогүй. Өөрөөр хэлбэл, хүний оршихуйн феномен бол Би-гийн ахуйгаас өөрөөс нь гарвалтай, ухамсрын өөрийн имманент өгөгдөхүүнүүд байдаг¹⁵.

Би-гийн ахуй “юу” гэх тодорхойлолтонд илрэх боломжгүй, тэр нь “хэрхэн” оршиж байгааг тоочин илэрхийлж болох тухай бид өмнө өгүүлсэн билээ. ХХ зууны философи онолуудаас феноменологи баримтлал хүний ухамсарын феноменуудыг тийм аргаар илэрхийлдэг нь онцлог юм. М.Хайдеггерын үзснээр “юун түрүүнд “феноменологи” нь аргын тухай ойлголтыг илэрхийлдэг. Тэр нь философийн судлах зүйлийн агуулга-“юу” гэдгийг бус, харин түүний “хэрхэн” гэдгийг тодорхойлдог”¹⁶ гэж бичжээ. Ийнхүү феноменологи нь ухамсрын имманент өгөгдөхүүнүүдийг судалж, тоочин илэрхийлдэг учраас Би-гийн ахуйг “гэрэлтүүлэх” үндсэн арга зүй болж өгөх учиртай.

Феноменологи хэмээх энэ сургаалын эхлэлийг Э.Гуссерльтэй холбон үздэг билээ. Тэрээр мэдлэгийн шинжлэх ухаанч чанарыг эрс субъективизмтай нэгтгэж чадсан бөгөөд “ухамсрыг цэвэрлэх ажиллагаа” антипсихологизмд хүргэдгийг бидэнд харуулахыг оролдсон. Үүний үр дүнд бий болсон ухамсрын цэвэр феноменууд гадны үйл явц юмуу психофизик үйл явцаар нөхцөлдөж бий болоогүй бөгөөд харин өөрөө өөрийгөө илт илрүүлдэг нь тодорхой байдаг. Ийм аргаар бас экзистенциал ухамсрын феноменуудыг (хүний оршихуйн феноменуудыг) илрүүлэх (К.Ясперсийн хэллэгээр бол, “гэрэлтүүлэх”) бас боломжтойг энд хэлэх хэрэгтэй юм.

Э.Гуссерлийн феноменологийн үндсэн зарчим бол: ухамсарт *илт чанартай* тусгагдаагүй ямар ч зүйлийг (одоохондоо) үнэн гэж хүлээн зөвшөөрөх боломжгүй. Шинжлэх ухааны, тэр дунд шинжлэх ухааны философийн байр сууринд эрмэлзэж байдаг психологийн судлагдахуун гэнэн шинжтэй бөгөөд хэзээ ч илт чанартай байж чаддаггүй. Учир нь объект-субъект харилцааны үүднээс асуудалд ханддаг. Гэтэл ухамсар өөрөөсөө гадна байгаа

¹² См.: Лосский Н. О. Мир как осуществление красоты. Основы эстетики. - М., 1998.

¹³ Сартр Ж. П. Экзистенциализм бол хүмүүнлэг үзэл мөн. - УБ., 2007. - 9 дэх тал.

¹⁴ Хүний оршихуйг экзистенциал дихотоми, түүхэн дихотоми хоёрын хүрээнд Э. Фромм тодорхойсныг энд үндэс болгов. Үүнд: түүхэн дихотоми (эртний Грекийн боолын институци гэх мэт) нь зарчмын хувьд аль нэг түүхэн эрин үед шийдвэрлэгддэг тул хүний оршихуйн салшгүй хэсэг болдоггүй гэж үзсэн байна. Харин экзистенциал дихотомууд нь (үхэл ба амьдрал гэх мэт) бидний оршихуйд гүнзгий нөлөө үзүүлдэг. Түүхэн дихотомыг хувь хүний түвшинд рационализац, нийгмийн түвшинд идеологиор шийдвэрлэх гэж хүн төрөлхтөн оролдож ирсэн ажээ. Гэтэл экзистенциал зөрчлийг идеологиор шийдвэрлэх гэж оролдож ирсэн ч (жишээ нь социал институци: ийм байгаад чиний буруу байхгүй гэх мэт) тэр нь хүний оршихуйд үндэстэй учраас арилашгүй гэж Эрих Фромм үзжээ. (См: Фромм Э. Человек для себя. - Мн., 1992.)

¹⁵ Н.А.Бердяев «Би»-гийн онтологи ганцаардалын тухай өгүүлжээ. Ийм ганцаардал нь амьдралын эмпирик нөхцлөөс (ойр дотны хүмүүсээ алдах гэх мэт) бий болдоггүй ба «Би»-гийн ахуйгаас гарвалтай ажээ. (См: Бердяев Н. Я и мир объектов. Опыт философии одиночества и общения. - Париж., 1934.)

¹⁶ Шопенгауэр А. Мир как воля и представление. //Хрестоматия по истории философии. В 3 ч: Ч. 2. - М., 1997. - С.52.

юмсыг (өөрөөрөө байгаа юм буюу вещь в себе) эзэмдэж, тэдгээр нь илт чанартай өгөгдөх боломжгүй. Гагцхүү ухамсрын өөрийх нь үйлдлийн үр дүнд бүтсэн юмс, түүний утгыг ухамсар илт харуулдаг. Тийнхүү Э.Гуссерль шинжлэх ухааны мэдлэгийн «археологийн» үр дүнд – ухамсар интенциональ төлөвт оршдог гэсэн дүгнэлтэнд хүрсэн буй.

Ухамсрын тийм төлөвт анх анхаарал хандуулсан хүн бол түүний багш Ф.Брентано байлаа. Түүний үзлээр бол, “...юмс интенциональ төлөвт оршдог гэсэн ... схоластикуудын үзэл аливаа психик феноменд хамаатай. Бид...түүнийг объект (гэхдээ үүнийг бодит юм гэж ойлгож болохгүй) руу чиглэсэн төлөв буюу имманент өгөгдөхүүн гэж нэрлэх байна. Аливаа психик феномен...объект руу чиглэсэн төлөвт оршдог”¹⁷. Э.Гуссерль энэ санааг хүлээн авсан боловч, хэрэв “объект руу чиглэсэн төлөв”-ийг сэтгэцийн “имманент өгөгдөхүүн” гэж үзвэл психологизмоос ангижрах боломжгүйд хүрнэ. Ийнхүү тэрээр интенциональ төлөвт орж байгаа юмсыг бодит өгөгдөхүүн ба интенциональ өгөгдөхүүн гэж ялгажээ*. Хэрэв бид ухамсрын зөвхөн бодит өгөгдөхүүнийг (Ф.Брентаногийн «имманент өгөгдөхүүн») авч үзэх юм бол, юмс хэдий ухамсарт өгөгдсөн байх боловч тэр юмыг өөрийг нь илрүүлэх боломжгүй. Учир нь одоо-энд байгаа бодит, индивидуал юмсын ахуй санамсаргүй шинжтэй. Эмпирик юмсын мөн чанарт, тэр нь яг тийм байгаагаас бас өөр байх (өөрөөр хэлбэл, өөр газар, өөр хугацаанд, өөр хэлбэрээр байх) боломж агуулдаг. Туулан мэдэрсэн үзэгдлийг юмсын өөртэй нь адилтгадаг явдал бол психологизмын гол алдаа гэж Э.Гуссерль үзэж байв. Тухайлбал, энэ улаан өнгөтэй сарнай байна гэвэл зөвхөн мэдрэхүйн замаар мэдсэн хэрэг биш. Энэ сарнай, энэ улаан өнгийг мэдэрхүйгээр мэдэж болох ч тэдгээрийн холбоос, ерөнхий өнгө, ерөнхий сарнай, ерөнхий улаан сарнайн төлөв сэрэлд хүртээлгүй юм. Харин үүнийг “категорийн интуицийн” тусламжтай танин мэдэж, интенциональ объект (феномен) бий болдог. Өөрөөр хэлбэл интенциональ объект бий болоход дан бодит өгөгдөхүүн хүрэлцээгүй юм. Үүнд ухамсрын интенци тусаж буй матери заавал бодит өгөгдөхүүн байх шаардлагагүй. Энэ нь хийсвэр юмс ч байж болох юм. Тухайлбал, эртний мифүүдийг утгагүй зүйл гэж үздэггүй билээ. Бид перцепци + концепц = феномен гэж томъёолж болох боловч феномений ертөнц үүнээс илүү баялаг агуулгатай, феномен бүр олон давхрагатай агаад өгөгдөхүүн, утга хоёр түүний үндсэн давхарга юм.

Интенциональ төлөвт оршдог цэвэр ухамсарт хүрэх арга бол феноменологи редуцци юм. Хэрэв философидож байгаа субъектийн үүднээс (first person point of view) мэдлэгийн мадаггүй үнэний тухай асуудалд хандвал ердийн туршлага, шинжлэх ухааны мэдлэгийн тогтоц шүүмжлэл даахгүй. Энд, ертөнц бодитой оршиж байгаа эсэх (ахуйн) тухай асуудлыг

¹⁷ Брентано Ф. Психология с эмпирической точки зрения. //Брентано Ф. Избранные работы. -М.,1996. - С.33.

* Гуссерлийн феноменологид ухамсрын үйлийг тэмдэглэхэд «Erlebnis» гэдэг үг гол төлөв ашиглагддаг. Энэ үгийг орос хэлэнд «переживание» гэж тогтсон утгатай орчуулдаг (er-leben-«про-жить», почти что «пере-жить») бол, англи хэлэнд «lived-process» юмуу «experience» гэж хоёр өөр хувилбараар орчуулсан нь тааралддаг. Харин манайд «догдлон мэдрэхүй», «сэтгэл хөдлөл», «зовинол», «туришлага» гэх мэтээр орчуулдаг. Уг тохиолдолд «туришлага» гэж орчуулах боломжгүй. Учир гэвэл туришлага гэдэг нь шинжлэх ухаан, шашин болон ерийн ухамсрын түвшинд хүртэл хэрэглэгддэг: экспериментал туришлага, шашны туришлага, ажлын туришлага гэх мэт. Тийм ерөнхий туришлага эзэн биегүй байдаг. Гэтэл феноменологийн «Erlebnis» бол персонал шинжтэй юм. Мөн «догдлон мэдрэхүй» юмуу «сэтгэл хөдлөл» гэвэл хэт эмоционал шинжтэй (Догдлох-юманд яарах тэвдэх, сочих зэрэгт бие махбод болон сэтгэл хөдлөх; бие догдлох; сэтгэл догдох; уулзахсан гэхээс зүрх догдолж байв; (Я Цэвэл. Монгол хэлний тайлбар толь. – УБ., 1966. 195 дахь талд үз). Харин феноменологийн уг ойлголт гносеологи шинжтэй байдаг. Хэрвээ тэгж орчуулсан тохиолдолд энэ үгний утгын нөхцлийг заах хэрэгтэй. Психологийн аливаа ойлголт заавал «lived-process»-ийг дамжин, түүгээр тодорхойгодож байдаг. Иймд нэг талаас, энэ бол психологийн ойлголт мөн. Энд явагдаж байгаа үйл явц бол, Гуссерлийн хэлдгээр «хүн болон адгуусны сэтгэцтэй холбоотой». Өөрөөр хэлбэл энэ бол психофизик үйл явц мөн. Харин феноменологи бол сэтгэцийг биш, харин цэвэр ухамсрыг судалдаг. Иймд, нөгөө талаас энэ бол цэвэр ухамсрын үйлдлийг тэмдэглэдэг ойлголт юм. Гол ялгаа нь уг ойлголтыг «феноменологи удирдамж»-ийн хүрээнд хэрэглэж байна уу аль эсвэл «жам ёсны удирдамжид» ойлгож байна уу? гэдэгт оршино. Бид уг ойлголтыг «туулан мэдэхүй» гэж буулгасан. Энэ нь «юмыг дайрч нэвтрэн өнгөрөх, амсах» гэсэн санаа илэрхийлнэ. Энэ ойлголтын психологи утгыг Гуссерлийн зохиолоос эш татан толилуулвал: «Хэрэв хэн нэгэн хүн 1866–1870 онд болсон дайныг үзэж туулсан (пережил война) гэж ярьж байгаа бол, энд «үзэж туулсан юмс» гэж байгаа нь гадаад үйл явдлуудын цогц бөгөөд туулан мэдрэх явдал нь (Erleben) үнэлэх хүртэх, мөн энэ үйл явдлуудыг өгөгдөхүүн буюу эмпирик Би-тэй холбоотой объект болгон хувиргадаг бусад үйлээс (акт) бүтдэг». Харин феноменологи утгаар бол, эмпирик Би-тэй холбоотой үйл явцуудыг «хашилтанаас гаргаж» байж интенциональ туулан мэдэхүүд хүрдэг. (Мөн Гуссерлийн зохиол бүтээлд «соприкосновение-empathic experience-зовинол», «вчувствование-догдлон мэдрэхүй» гэх зэрэг ойлголтууд бий).

хэрэгсэхгүй үлдээх ёстой. Ертөнцийн ахуйн тухай шүүн хэлэлцсэн оюун ухааны ямар ч үйлдэл хийхгүй (тиймээс ямар ч төрлийн мэдлэгийн тогтоцыг хүлээн авахгүй) байхыг Э.Гуссерль “эпохе” нэр томъёогоор илэрхийлдэг. Асуултын тэмдэг тавьж болох эргэлзээтэй зүйлсийг “хашилтаас гаргаж” ухамсрыг цэвэрлэх ёстой. Үүнд, хүн, түүний нийгэм, түүх хийгээд, байгалийн тухай эмпирик баримт эргэлзээ төрүүлэхгүй байж чадахгүй. Мөн хамгийн чухал нь миний эмпирик егo, түүний психофизик амьдралыг хүртэл хашилтаас гаргах хэрэгтэй. Гэхдээ хашилтаас гарсан юмсын ахуй няцаагдаж байгаа хэдий ч тэр нь огт байхгүй болсон хэрэг биш юм. Энэ бол тэдгээрийг эргэлзээтэй гэдгийг л тогтоосон арга зүйн шинжтэй ажиллагаа. Феноменологийн редукци явагдаж дуусахад “хашилт дотор” юу үлдэх вэ? Үүнд: эргэлзэж байгаа егo эргэлзээгүй оршиж байна. Тэгвэл эргэлзээгүй оршин байгаа тэр егo гэж юу вэ? Энэ нь мэдээж психофизик субъект биш гэдэг нь тодорхой, учир нь тэр хэдийнээ хашилтанд үлдээгүй. Энд, феноменологийн редукци явагдаж дуустал бид мэдэх боломжгүй өөрсдийн тэр онцгой оршихуйтай тулгарна. Энэ бол *трансцендентал субъектив төлөв буюу трансценденталь егo* юм. Э.Гуссерлийн үзлээр, “тийнхүү редукцид орсон егo туйлын баттай замыг эрж явсаар өөрийн цэвэр дотоод талбараасаа объектив гадаад талбарыг нээдэг”¹⁸.

Э.Гуссерлийн “интенциональ төлөв” гэдэг ойлголт танин мэдэхүйн онолын объект субъектын харилцааны асуудлыг шийдвэрлэх чухал хэрэгсэл болж өгсөн. “Хэрэв танин мэдэхүйн онол ахуй, ухамсар хоёрын хоорондын харилцааны асуудлыг судлахыг зорьж байгаа бол тэрээр ахуйг зөвхөн ухамсартай харилцан хэмжигдэх ухагдахуун, ухамсрын шинж чанаруудтай харгалзан “ухаарсан” зүйл гэж үзэх учиртай”¹⁹. Феноменологийн үүднээс ахуй, ухамсар хоёр салшгүй холбоотой бөгөөд объект субъект хоёрыг тусгаарлах нь бодит байдлыг гажуу тольдоход хүргэдэг. Энд ухамсраас гадна ахуй, ахуйгаас гадна ухамсар яригдахгүй ажээ.

Сонгодог танин мэдэхүйн онолд (Р.Декартаас И.Кант хүртэл) цэвэр ухамсрыг Би=Би буюу формаль адилслын хүрээнд төлөөлдөг байв. Харин И.Фихте Би-гээс Би болон Би-бусыг үндэслэх гэж оролдсон боловч “субстанци бол өөрөө өөрийнхөө шалтгаан мөн” гэсэн субстанциал үзлийн хүрээнээс гарч чадалгүй үлдсэн юм. Тийм аваас ухамсар өөрөөсөө өөр юмсыг тольдох боломжгүй өөртөө түгжигдмэл зүйл, үүнийг Г.Лейбницийн хэллэгээр илэрхийлвэл “монадууд цонхгүй” юм. Энэ нь ухамсар төдийгүй ухамсрын объект статик зүйл гэж үзэхэд хүргэж байв. Харин ухамсар интенциональ төлөвт оршдог гэсэн нь тэр нь ерөөс нээлтэй, цэлмэн тодорсон зүйл (разомкнутость) гэж үзэх боломж олгосон. Интенциональ төлөв бол гадагшаа чиглэсэн, өөр юманд хандсан, өөрийн заагийг давсан байдал юм. Ийм нөхцөлд юмсыг ухамсраас үндэслэн гаргах шаардлагагүй, *юмс ухамсарт анхнаасаа өгөгдсөн* байдаг. Иймд цэвэр өгөгдөхүүн, цэвэр ухамсар хоёр нэг зүйл юм.

Ухамсар бол туулан мэдэрхүйн (переживание) эцэс төгсгөлгүй урсгал мөн гэж феноменологи үздэг. Ухамсрын интенциональ объект статик зүйл биш тул ухамсрын интенци тэр зүйлийг дахин дахин бүтээдэг. Тэр хирээр интенциональ объект шинж чанарын хувьд илүү баялаг болдог байна. Түүнийг эмхлэн бүтээх явдал хичнээн удаан ч явагдаж болно. Яагаад гэвэл интенциональ объектийн хаялбар (горизонт) шавхагдашгүй. Энэ бол ухамсар нэг төлөвөөс нөгөөд шилжиж өөрийн заагийг байнга даваж байна гэсэн үг юм. Тухайлбал, “... кубыг хүртэхэд нарийн ярвигтай, нэгдсэн интенци илэрдэг: харах өнцгөөс шалтгаалан кубын “үзэгдэл”-д үл тасалдах олон хувилбар, түүнд тохирох ялгаатай талууд, мөн тухайн агшинд харагдаж байгаа “урьд тал” ба тухайн агшинд харагдахгүй учраас бараг “тодорхойгүй” үлдсэн “хойд тал”-ын ялгаа бий болдог. Гэхдээ кубын үл харагдах талуудыг ч оршин байгаа гэж үзнэ* . Янз янзын үзэгдэл-талууд, тэдгээрийн синтезийн аргыг ажиглавал мөчлөг тус бүр нь ямар нэгэн юмны “тухай-ухамсар” болох нь харагдана. Үүнд шинэ мөчлөг бий болоход ухамсрын бүхэллэг синтез нэгдлийн нэг ч агшин алдагдахгүй. Тэр нь нэг л объектын тухай ухамсар хэвээр үлдэнэ”²⁰. Ийнхүү ухамсрын интенциональ объектыг эмхлэн бүтээх ажил

* Энэ нь ухамсрын динамик шинжийг илтгэнэ

¹⁸ Гуссерль Э. *Картезианские размышления*. // Гуссерль Э. *Сборник*. - М., 2000. - С.327.

¹⁹ Гуссерль Э. *Философия как строгая наука*. // Гуссерль Э. *Сборник*. - М., 2000. - С.684.

²⁰ Гуссерль Э. *Феноменология: Статья в Британской энциклопедии*. // "Логос". 1/1991. - С.12 - 21

субъектийн дотоод цаг хугацаан дотор явагддаг байна. Энэ цаг хугацаа эргэлт буцалтгүй бөгөөд ухамсрын интенцүүд ар араасаа цуврана. Гэхдээ шинэ интенци үүсэх бүрт тэр нь өөр объектыг биш, харин өмнөх интенцийн тухайлж байсан объектод хандаж байгаа нь буюу “ухамсрын бүхэллэг синтез нэгдлийн нэг ч агшин алдагдахгүй” байгаа нь ухамсрын онцгой чадвар болох “идентификацитай” нь холбоотой ажээ. Тийнхүү Гуссерлийн *феноменологи бол цэвэр ухамсрын динамизм* мөн.

Феноменологид феноменыг тогтсон субстанционал ойлголтоор илэрхийлэх боломжгүй. Харин “юмсын өөрт нь буцаж үзэх” замаар түүнийг гагцхүү тоочин илэрхийлдэг. Тоочилт бол феноменологич хүн оюуны зөн билэгтээ харж байгаа зүйлээ илэрхийлэх арга юм. Тэр нь ямар нэгэн эмпирик юмс, үйл явдлыг тоочин илэрхийлэхээс эрс ялгаатай. Феноменологид тоочин илэрхийлж байгаа үзэгдлүүд тоочин илэрхийлэх явцад бий болдог. Тэгвэл, хэрэв юмс тоочин илэрхийлэхээс өмнө байгаагүй бол, энд тоочин илэрхийлэх тухай биш харин логик зохиомж бүтээх тухай ярих хэрэгтэй биш үү? гэж асууж болох юм. Э.Гуссерлийн үзлээр, эмпирик юмсыг тоочин илэрхийлэхээс өмнө тоочин илэрхийлж байгаа юмс оршин байдаг. Гэтэл ухамсарт илт чанартай өгөгдөж буй феноменийг тоочин илэрхийлэх явдал парадоксал шинжтэй: тоочин илэрхийлж байгаа үзэгдэл тоочин илэрхийлэхээс өмнө оршдог (эс тэгвээс түүнийг тоочих боломжгүй байхсан) бас оршдоггүй. Учир нь юмс интуицэд өгөгдсөн хойно тийнхүү оршин байсныг бид олж мэдэхийн хамт бас шинэ юмсыг бүтээдэг. Үүнийг Гуссерль “эмхлэн бүтээхүй”²¹ гэж нэрлэдэг. Тиймээс феноменологи арга зөвхөн редукци төдийгүй мөн бүтээхүйг бас шаарддаг.

Өмнө дурдсанчлан экзистенциализм агуулга болон арга зүйн хувьд сонгодог философиос ялгаатай онтологи сургаал боловсруулсан-тэр нь Би-гийн ахуйн тухай субъектив онтологи билээ. Ийм онтологи сургаал боловсруулахад Э.Гуссерлийн феноменологийн үндэслэлүүдийг ашиглах бололцоотой ба экзистенциалистууд ч тийнхүү ашигласан байдаг. Бид ийм бололцоог экзистенциализмын зарим төлөөлөгчдийн үндэслэлүүд дээр тулгуурлан өмнө өгүүлсэн зүйлсээс дүгнэн гарахыг оролдоё.

1. Ухамсар, түүний агуулгыг бүхэлд нь психологийн баримтуудаар тайлбарлахыг Э.Гуссерль эрс эсэргүүцэж, антипсихологист байр суурь баримталдаг. Энэ нь экзистенциализмын субъектив онтологи сургаалд мөн хамааралтай гэж үзэж болох юм. Хэрэв психологизмын үүднээс хандвал тийм онтологи сургаал боловсруулах боломжгүй. Тухайбал, Би-гийн ахуйн модусууд сэтгэцийн өгөгдөхүүнүүд биш, психологийн судладаг Би-гийн психофизик ертөнц бол тогтвортой, түгжигдмэл ертөнц байдаг. Харин экзистенциал Би-гийн ахуй бол өөрийн түгжигдмэл байдлаа байнга давж гардаг. Өөрөөр хэлбэл К.Ясперсийн хэлснээр “мифийн хэлээр сүнс, Бурхан тэнгэр, харин философийн хэлээр экзистенци, трансценденци гэж нэрлэдэг зүйлс бол ертөнц биш юм. Тэдгээр нь ертөнцийн юмс мэт “байдаг”-гүй”²². Хэрэв “Би” өөртэйгээ харьцаж өөрийн ахуйг гэрэлтүүлж байвал экзистенци мөн; Би өөртэйгээ ондоо зүйл мэт харьцвал тэр нь статус (социологи), сүнс (мифологи), амьд бие (биологи) мөн гэж Ясперсийг ойлгож болохоор юм.

2. Би-гийн ахуй бол өөрийх нь имманент мэдэрхүйгээр тодорхойлогддог цэвэр ухамсран ахуй мөн. Тухайлбал, аймшиг, ганцаардал гэх мэт экзистенциал мэдэрхүй гадаад ертөнцөөс үл хамаардаг өгөгдөхүүнүүд юм. Би-гийн ахуйг өөрийг нь өөрөөс нь ойлгохын тулд түүнийг эмпирик өгөгдөхүүнээс нь цэвэрлэх шаардлагатай. Э.Гуссерлийн редукцийн аргаар Би-гийн ахуйн тухай шинжлэх ухааны тогтоцыг “хашилтанаас гаргаж” цэвэр ухамсран ахуйд хүрнэ. Редукцийн үр дүнд хүрсэн цэвэр “ухамсран ахуйг” (Би-гийн ахуйг) психологи юмуу антропологийн үүднээс тайлбарлах боломжгүй. Тухайлбал, М.Хайдеггерийн хувьд Би-гийн ахуй бол “... психологи, антропологи болон биологиос зарчмын хувьд ялгаатай онтологийн асуудалд хамаардаг”²³. Тэрээр “феноменологийн универсал онтологи” бүтээхдээ онтологи дифференциаци: онтик ба онтологи ялгааг гаргаж ирсэн нь Э.Гуссерлийн редукцийг санагдуулдаг. Энэ бол оршин буй юмсын ахуй хэрхэн илт тодрох тухай юм. Шинжлэх

²¹ конституирование

²² Ясперс К. *Философия. Книга вторая. Просветление экзистенции.* - М., 2012. - С.3.

²³ Ясперс К. *Философия. Книга вторая. Просветление экзистенции.* - М., 2012. - С.3.

ухаан юмсыг онтик байдлаар авч үздэг бол, феноменологи болон экзистенциализм юмсыг онтологи байдлаар тодорхойлон судладаг. Хайдеггерийнхаар энэ нь оршин буй юмсыг биш, харин юмсын ахуйг-юмсын утгыг феноменологи судалдаг гэсэн үг;

3. Гуссерль ухамсар интенциональ төлөвт оршдог гэж үздэг. Энэ бол угтаа цэвэр ухамсрын динамизм мөн гэж бид тэмдэглэсэн. Экзистенциализмд яригддаг Би-гийн ахуй бас интенциональ төлөвт оршдог гэж үзэж болно. Учир нь интенциональ төлөвт оршиж буй ухамсар өөрийн заагийг ямагт давж байдаг лугаа адил Би-гийн ахуй өөрийн зааг хязгаараа ямагт давж гардаг. Ухамсран ахуй бол ямагт трансцендичилдэг буюу “ямагт өөрөөсөө гадна байдаг”. Экзистенциализмд Би-гийн ахуйн интенциональ төлөвийг зовинол-цаг хугацааны модусууд, төсөл, аймшиг, үхэл, юу ч биш зэрэг категориор илэрхийлдэг гэж үзэж болно.

4. Э.Гуссерлийн философийн гол судлагдахуун-цэвэр ухамсар болон экзистенциализм дахь Би-гийн ахуй хоёр бол цэвэр субъектив төлөв мөн. Ухамсрын феноменыг феноменологи тоочин илэрхийлдэг. Мөн Би-гийн ахуйг “бэлэн ахуй” мэт судлах бололцоогүй тул бас “хэрхэн” гэдгээр тоочин илэрхийлдэг буюу хүний оршихуйн феномены трансценденталь үндсэнд (интуицээр) нэвтэрч гэрэлтүүлэн ил гаргадаг.

5. Тийнхүү Би-гийн ахуй бол цэвэр ухамсран ахуй буюу трансценденталь субъектив төлөв юм.

ABSTRACT

Existentialism is the most influential movement in twentieth-century philosophy which focuses on human existence. It overcame traditional understanding about human being to develop existential ontology. That ontology as methodology was influenced by Husserl's phenomenology. Especially 'pure' or 'transcendental' science of subjectivity to establish existentialism as the ontology. The article deals with the theoretical roots of existentialism.

НОМ ЗҮЙ

1. Антология мировой философии. – М.,1971. Т. 3.
2. Аристотель. Сочинения в четырех томах. Том 1. – М.,1976.
3. Бердяев Н. Назначение человека: Опыт парадоксальной этики. – Париж.,1931.
4. Бердяев Н. Я и мир объектов. Опыт философии одиночества и общения. - Париж., 1934.
5. Бренгано Ф. Избранные работы. -М.,1996.
6. Больнов О. В. Философия экзистенциализма. – СПб.,1999.
7. Гегель Г. В. Ф. Энциклопедия философских наук. – М., 1974. Т. 1. – С. 123.
8. Гомбосүрэн Ц. Христос шашны орчин үе дэх философи чиглэлүүд. –УБ., 2001.
9. Гуннар Скирбекк. Нилс Гилье. История философии. - М., 2000.
10. Гуссерль Э. Сборник. - М., 2000.
11. “Логос” . 1/1991.
12. Лосский Н. О. Мир как осуществление красоты. Основы эстетики. - М.,1998.
13. Новая философская энциклопедия. В Четырех томах. Том III. - М., 2010.
14. Реале Д. Антисери Д. Западная философия от истоков до наших дней. Том 4. - СПб.,1997.
15. Сартр Ж. П. Экзистенциализм бол хүмүүнлэг үзэл мөн. Орч. Ү. Нямдорж. - УБ., 2007.
16. Современный экзистенциализм. Критические очерки. – М.,1966.
17. Фромм Э. Человек для себя. – Мн.,1992.
18. Хайдеггер М. Бытие и время. - М.,1997.
19. Хрестоматия по истории философии. В 3 ч: Ч. 2. - М.,1997.
20. Ясперс К. Философия. Книга вторая. Просветление экзистенции. - М., 2012.